"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын даргын
2023 оны 03 дугаар сарын 31 -ний өдрийн А/07
дугаар тушаалын 20 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

☐ Нийслэлийн Засаг даргын захирамж, Газрын захирлын тушаалаар байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамж

Дагаж мөрдөх огноо: 2023.04.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2023.03.31

| 1. Байгууллагын нэр | 2. Нэгжийн нэр |
|---|---|
| "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГазар | Тохижилт үйлчилгээний алба |
| **Албан тушаалын нэр:**<br>Ашиглалтын инженер | **Албан тушаалын ангилал Зэрэглэл:**<br>ТҮ-8 |
| **Ажлын цаг:**<br>8/40 | **Ажлын байрны албан ёсны байршил:**<br>Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 32-р хороо, Хүй долоон худаг |
| **Хөдөлмөрийн нөхцөл:**<br>Хэвийн | **Онцгой нөхцөл:**<br>Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

**Албан тушаалын зорилго:**

Хүй долоон худгийн талбайд байрлалтай барилга байгууламж, тоног төхөөрөмж, гадна тохижилтын ашиглалт, хамгаалалт, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, машин техникийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан үр дүнтэй зохион байгуулж ажиллах

**Албан тушаалын зорилт:**

1. Хүй долоон худгийн инженерийн асуудлууд, сантехник, цахилгааны засвар, үйлчилгээ болон гэр баазын тохижилт, үйлчилгээтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах.
2. Сантехник, цахилгаан, багаж хэрэгсэл бусад шаардлагатай бараа материал, барилгын засвар үйлчилгээний материалын захиалга гаргаж шаардлагын дагуу захиалж, засвар үйлчилгээ хийлгэх
3. Хөдөлмөрын аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг өдөр тутамын үйл ажиллагаандаа мөрдүүлж ажиллах. Хөдөлмөр хамгааллын төлөвлөгөө гаргах, төсөв боловсруулах.
4. Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг чанд мөрдөх.
5. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | **Хариуцлага оролцооны хэлбэр**<br>Туслах-Т<br>Хариуцан гүйцэтгэх-Г<br>Хянах-Х<br>Шийдвэрлэх-Ш |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1. Хүй долоон худгийн тохижилт, засвар үйлчилгээ, цэвэрлэгээг зохион байгуулан, талбайд байрлалтай барилга байгууламж, тоног төхөөрөмж, гадна тохижилтын ашиглалт, хамгаалалтыг хариуцан техникийн ашиглалт, засвар үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулах.<br>2. Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээтэй холбоотой зардлуудыг цаг хугацаанд нь гарган Санхүүгийн албанд өгч уялдаа холбоотой ажиллах<br>3. Тээврийн хэрэгсэл, техникүүдийг ажилд гаргах, осол авааргүй ажиллах тал дээр анхаарч баримт бичгээр баталгаажуулан ажиллах, техникүүдийн ашиглалтын талаар бусад аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах<br>4. Автомашин механизмуудын ашиглалт сэлбэг хэрэгслийн элэгдэл хорогдол, хувийн хэргийн баяжилтийг хөтлөн тогтмол бичилт хийх, бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавих<br>5. Байгууллагын ажилтнуудын ашиглавал зохих МУ-ын хууль, ЗГ-ын тогтоол, НИТХ-ын тогтоол, НЗД-ын тушаал, захирамж, журам заавар, байгууллагын даргын тушаал, байгууллагын дүрэм, дотоод журам, норм норматив, стандарт зэрэг тогтоомжийн лавлах /эрх зүйн актуудын эмхтгэл/-ийн дагуу үр дүнтэй ажиллах<br>6. Ажилтны сар, улирал, жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан тогтсон хугацаанд тайлагнан удирдлагад танилцуулан ажиллах. | Чиг үүргийн хэрэгжилт хангагдсан байна.<br><br>Уялдаа холбоотой ажилласан байна.<br><br>Зөрчил дутагдалгүй техник ашиглалт хангагдсан байна.<br><br>Хэрэгжилт хангагдсан байна.<br><br>Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.<br><br>Төлөвлөгөөний биелэлт хангагдсан байна. | Г,Ш<br><br>Г<br><br>Г<br><br>Г,Х<br><br>Г<br><br>Г |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1. Тохижилтонд шаардлагатай багаж, хэрэгсэл, бусад материалыг жагсаалтаар цаг хугацаанд нь Санхүү хөрөнгө оруулалтын албанд өгөх.<br>2. Улсын болон тэмдэглэлт ойн баяр наадмуудыг зохион байгуулахтай холбоотой засвар, үйлчилгээний материалын төсвийг Санхүү хөрөнгө оруулалтын албанд гаргаж өгөх.<br>3. Тохижилттой холбоотой эдийн засгийн тооцоо судалгаа, шинэ санаа гарган удирдлагад танилцуулах.<br>4. Хүй долоон худгийн жуулчны баазын тохижилттой холбоотой шинэ санаа санаачлага гарган ажиллах<br>5. Цаг үеийн холбогдолтой ажлуудыг шуурхай зохион байгуулж үр дүнг тооцох<br>6. Ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой | Байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдсан байна.<br><br>Хэрэгжилт хангагдсан байна.<br><br>Шинэ санааны хэрэгжилт хангагдсан байна.<br><br>Тухай бүрд хэрэгжилт хангагдсан байна. | Г<br><br>Г<br><br>Г<br><br>Г |

| | | | |
|---|---|---|---|
| | байгууллагын дарга болон албаны ахлах мэргэжилтэнгээс өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь хийж гүйцэтгэн, тайлагнаж, уялдаа холбоотой хамтран ажиллах.<br>7. Байгууллага, нэгжээс зохион байгуулж байгаа аливаа сургалт, мэдээлэлд цаг тухай бүрд нь хамрагдах<br>8. Хүй долоон худаг дахь тохижилт үйлчилгээний ажилчдад ХАБЭА-н сургалт явуулж хяналт тавиж ажиллах | Үүрэг даалгаварын биелэлт хангагдсан байна.<br><br>Мэдлэг, ур чадвар дээшилсэн байна.<br>ХАБЭА хэрэгжилт хангагдсан байна. | Г<br><br>Г<br><br>Г |
| **3 дугаар зорилтын хүрээнд** | 1. Ёс зүйн дүрэм, сахилга хариуцлага, захирах захирагдах ёсыг баримтлан ажиллах<br>2. Удирдлагаас хариуцуулсан бусад ажлыг зохион байгуулж тайлагнах<br>3. Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллах<br>4. Батлагдсан ХХНЖ-ын хүрээнд баримт бичгийн заавар журмын дагуу бүрдүүлэх, хугацаанд нь архивт шилжүүлэх<br>5. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу Үндэсний их баяр наадмаар ажиллах.<br>6. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах | Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.<br><br>Архивын заавар стандартад нийцсэн байна.<br><br>Дүрмээр хүлээсэн үүрэг хангагдсан байна. | Г<br><br>Г<br><br>Г |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **Боловсрол** | Бакалавр, болон түүнээс дээш зэрэгтэй |
| **Мэргэжил** | Барилгын инженер, механикч, автын инженер |
| **Мэргэшил** | Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалтанд хамрагдсан байх |
| **Туршлага** | Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан ажлын дадлага туршлагатай байх. |
| **Ур чадвар** | - Нягт нямбай, хичээнгүй зан чанартай<br>- Багаар ажиллах, удирдан зохион байгуулах, асуудлыг түргэн шийдвэрлэх<br>- Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих<br>- Хэл яриа /тодорхой ойлгомжтой ярь, тайлагнах/-ны чадвар<br>- Хувийн зохион байгуулалт сайтай, цагийн менежмент сайтай<br>- Компьютерийн өргөн хэрэглээний программууд (MS Word, Excel, Power point autokad ), интернэт, дотоод сүлжээний орчин дээр ажиллах чадвартай байх. |

## IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| |
|---|
| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалтны нэр:**<br>Газрын дарга<br>Тохижилт үйлчилгээний албаны дарга |

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>Байхгүй | Бусад харилцах субъект:<br>1. Хамтран ажиллаж буй гэрээт байгууллага болон хувь хүн |
|---|---|

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: |
|---|---|
| "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн<br>А. Цэнгэлсайхан ............................ А.Цэнгэлсайхан<br>2023 оны 03 дугаар сарын 31-ны өдөр | "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Дарга<br>............................ С.Сайнбаяр<br>(Тамга, тэмдэг)<br>2023 оны 03 дугаар сарын 31-ны өдөр |